



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 10 өдөр

Дугаар 1/07

Номгон

Г Бууцагаан сумын Баянбүрд багийн Г
спорт заалны барилгын барьцаа хөрөнгө
суллах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 444 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 2.9.1, 2.9.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн ББКД-64-0003/24 дугаар дүгнэлтийн дагуу Бууцагаан сумын Баянбүрд багийн спорт заалны барилгын гүйцэтгэл болох 52,839,656 (Тавин хоёр сая найман зуун гучин есөн мянга зургаан зуун тавин зургаан) төгрөгийг чөлөөлөхийг Санхүү төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т үүрэг болгосугай.

2.Барилга байгууламжийн гадна, дотор засал, үндсэн хийц, бүтээц, цэвэр, бохир ус, уур, хий, дулаан, цахилгаан, харилцаа холбооны зэргийн хэвийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар (Д.Алтангэрэл)-т, Бууцагаан сумын Засаг дарга (Х.Давгадорж)-д тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Наранбаяр)-д даалгасугай.

ДАРГА

Д.МӨНХСАЙХАН

625010015